

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулж яамны удирдлага, албан тушаалтнуудыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.3-т заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хоёр. Танилцуулга

Төрийн захиргааны удирдлагын газар 2024 онд 5 чиглэлийн 287 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан ба нийт хэрэгжилт **93** хувьтай байна. Хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 1/

№	Хяналтад байх арга хэмжээ	Нийт арга хэмжээ	Биелэлт /Хувиар/						Хугацаа болоогү	Үнэлгээ
			100	90	70	50	30	0		
1.	Төрийн захиргааны удирдлагын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	75	52	11	8	3	1	-	-	92.4%
2.	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	1	1	-	-	-	-	-	-	100%
3.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	88	69	-	15	-	-	-	4	95%
4.	Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	63	42	-	20	-	1	-	-	86%
5.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	60	49	-	10	-	1	-	-	93.8%
ДҮН		287	213	11	53	3	3	-	4	93%

2.1. Төрийн захиргааны удирдлагын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

ТЗУГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилтын 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бүрэн хэрэгжсэн 100%-тай 52, хэрэгжих

шатанд 90%-тай 11, 70%-тай 8, хэрэгжилт хангалтгүй 50%-тай 3, 30%-тай 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж **92.4** хувьтай байна.

Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд анхаарч ажиллах дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:

2.2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газарт хамаарах нийт 1 заалтаар үүрэг даалгавар өгсөн ба хэрэгжилт 100%-тай байна.

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрээр 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт өгөгдсөн 6 шийдвэрийн 88 заалтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ **95** хувьтай байна. Хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 3/

№	Шийдвэрийн төрөл	Заалт	Хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/					ХШҮ
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1.	МУ-ын хууль	2	-	1	-	-	1	70%
2.	УИХ-ын байнгын хорооны тогтоол	7	5	2	-	-	-	91%
3.	УИХ-ын тогтоол	7	5	2	-	-	-	91%
4.	Ерөнхий сайдын захирамж	1	1	-	-	-	-	100%
5.	Засгийн газрын тогтоол	28	21	6	-	-	1	93%
6.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	37	4	-	-	2	96%
Нийт		88	69	15	-	-	4	95%

2.4. Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Зам, тээврийн сайдын тушаалаар тус газарт нийт 63 заалтаар үүрэг даалгавар өгсөн ба бүрэн хэрэгжсэн 100%-тай 42, хэрэгжих шатанд 70%-тай 20, хэрэгжилт хангалтгүй 30%-тай 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж **89.4** хувьтай байна.

Хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

2.5. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тус газарт нийт 60 заалтаар үүрэг даалгавар өгсөн ба бүрэн хэрэгжсэн 100%-тай 49, хэрэгжих шатанд 70%-тай 10,

хэрэгжилт хангалтгүй 30%-тай 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж 93.8%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Гурав. Дүгнэлт

1.Төрийн захиргааны удирдлагын газрын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **93** хувьтай үнэлэгдсэн байна.

2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлууд зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнд:

2.1. Монгол Улсын Засгийн газар, Австралийн Холбооны Улсад Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах;

2.2. Салбарын захиргааны хэм хэмжээний актыг улсын хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.3. ЗТХЯ болон яамны харьяа байгууллагуудын хуулийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах;

2.4. Төсвийн ерөнхийлөн захираг -чийн жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа зорилт арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган холбогдох мэдээллийг хавсаргаж хэвших;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн зорилтод түвшинд хүрээгүй арга хэмжээнүүдийг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангах;

3. Тус яаманд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэлт хяналт тавих, шийдвэрлэлтийн мэдээ тайланг нэгтгэж гаргах үйл ажиллагаа хийгдэж байгаа боловч өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийх ажил орхигдсон байгааг анхаарч ажиллах;

4. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар журмын дагуу дээд шатны байгууллагад хүргүүлдэг тайлан мэдээг нэгтгэхдээ холбогдох газруудаас хэрэгжилтийг авахдаа оновчтой, тодорхой байдлаар, хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан тоо баримттай тогтоосонд хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлж хэвших.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР